



КҮНЗИЙН “ШҮҮМЖЛЭЛ ӨГҮҮЛЭЛ”

Эртний Хятадын гүн ухааны сэтгэлгээний сонгодог судар “Шүүмжлэл өгүүлэл” Монголд анх удаа бүрэн эхээрээ хэвлэгдэн гарлаа. Уг номыг хятад судлагч, орчуулагч, сэтгүүлч Урианхан овогт Мэнэрэлийн Чимэдцээ хятад эх хэлнээс орчуулж, 2005 онд хэвлүүлэн олон түмэндээ хүргэлээ.

Күнз нь эдүгээгээс 2500 гаруй жилийн өмнө амьдарч, туурвиж асан эртний хятадын их сэтгэгч, соён гэгээрүүлэгч, сод мэргэн агаад дэлхийн суут арван их сэтгэгчийн нэг хэмээн үнэлэгддэг бөлгөө.

Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл” зохиол нь гүн ухаан, улс төр, сайн засаглал, сайн ёс суртал, элбэрэл, нигүүслийг номлосон эртний хятадын сонгодог судар бөгөөд Күнзийн соёл суртлыг таних, түүний гүн ухааны сэтгэлгээг судлах хамгийн гол дурсгал юм.